



Завхан аймаг дахь Төрийн аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

2023 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ ШААРДЛАГЫН ХЭМЖЭЭНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ЗАА-2024/30-01-ШТА-ГА

Улиастай хот 2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Х.Болдбаатар
Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Заяа
Цахим хаяг: zayag@audit.gov.mn
Аудитор Н.Цогтсайхан
Цахим хаяг: tsogtsaikhann@audit.gov.mn
Аудитор Г.Нармандах
Цахим хаяг: narmandakhg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	4
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	5
АУДИТЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	6
БҮЛЭГ 1. СУМДЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНДЭСЛЭЛТЭЙ БОЛОВСРУУЛЖ, БАТЛУУЛААГҮЙ БАЙНА.....	7-11
БҮЛЭГ 2. БАТЛАГДСАН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ШААРДЛАГЫН ХЭМЖЭЭНД ХҮРЭЭГҮЙ, ГАЗРЫН ТӨЛБӨРИЙГ БҮРЭН НОГДУУЛАН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.....	11-19
БҮЛЭГ 3. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	20-23
ДҮГНЭЛТ	24-25
ЗӨВЛӨМЖ:	26-27
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	28-31
САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР	32



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/50

Улиастай

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт болон Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт тус тус хүргүүлэхийг шинжээч (Ч.Ундармаа)-д үүрэг болгосугай.

4. Аудитын ажлын нотлох баримтыг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Г.Заяа)-т даалгасугай.

5. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Заяа), аудитор (Н.Цогтсайхан, Г.Нармандах)- уудад үүрэг болгосугай.



Д.БАТ-УНДРАА

013010120

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ГЗБГЗЗЕГ	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ГЗБТ	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
АИХ	Ардын Их Хурал



Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн хийлээ.

Аудитын зорилт

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан, Аймгийн ИТХ, Засаг дарга холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Газар зохион байгуулалтын төлөвлөгөө үндэслэлтэй боловсруулагдсан эсэх
- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт нь үр дүнтэй эсэх
- Газрын мэдээллийн нэгдсэн системийн бүртгэл үр дүнтэй эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэрэгжилт, аймаг, сумдын Засаг дарга нарын газар олголттой холбоотой гаргасан захирамжууд, газрын төлбөрийн ногдуулалт, төлөлт зэргийг шалгасан. Ингэхдээ аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, аймгийн Татварын хэлтэс, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, сумдын ЗДТГ зэрэг байгууллагуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300,400,3000-3100,4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэрэг арга зүйг ашигласан.

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Х.Болдбаатар нар хянан удирдаж, ахлах аудитор Г.Заяа, аудитор Г.Нармандах, Н.Цогтсайхан нар 2024 оны 05 дугаар сарын 08-оос эхлэн 2024 оны 12 дүгээр сарын 13-ний хугацаанд хийж гүйцэтгэлээ

Ерөнхий мэдээлэл

Аймгийн ГХБХБГ нь тайлант онд 24 сумын 1268 нэгж талбарт 343,413 га газрыг олгохоор төлөвлөсөн бөгөөд биелэлт нь 72.7 хувьтай байна гэсэн мэдээллийг ирүүлсэн.

2023 онд Монгол улсын иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг батлах тухай Засгийн газрын 105 дугаар тогтоол, Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 53 дугаар тогтоолоор 288 иргэнд 33.7 га газрыг өмчлүүлэхээр баталж, аймаг, сумын Засаг даргын захирамжаар 222 иргэнд 26.9 га газрыг өмчлүүлсэн бөгөөд одоо эзэмшиж байгаа хашааны газраа өмчилсэн 35 иргэнд 3.5 га, шинээр өмчилсэн 187 иргэнд 23.4 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар тус тус өмчлүүлж тогтоолын хэрэгжилт 80 хувийн биелэлттэй байна.

Тайлант онд 1,055.7 сая төгрөгийн төлбөрийн ногдуулалтыг үүсгэснээс 69.1 хувийн төлөлттэй байна.

Газрын цахим бирж www.mle.mn сайтаар 2023 онд 122 нэгж талбарт дуудлага худалдаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 75 нэгж талбарт 3520 га газрын дуудлага худалдааг зохион байгуулан 194.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 1. СУМДЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ҮНДЭСЛЭЛТЭЙ БОЛОВСРУУЛАГДАН, БАТЛАГДААГҮЙ БАЙНА.

1.1. 22 СУМ НЬ ХОТ, ТОСГОНЫ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛААГҮЙ БАЙНА.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг “Тэгш хэм групп” ХХК нь аймгийн ЗДТГ-ын захиалгаар 24 сумын иргэд, орон нутгийн удирдлагуудын саналд үндэслэн ГЗБГЗЗЕГ-аас баталсан “Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх, арга зүй”-г ашиглан боловсруулж Аймгийн ИТХ-ын хуралдааны 2017 оны 31 дүгээр тогтоолоор батлуулжээ.

Тус газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний үндсэн 4 шийдэл нь дараах байдалтай байна.

1. Аймгийн газрын бүрхэвчээс 1.0 сая га бэлчээр хуурай хээр, цөлийн хээр ангилалд шилжин бүс нутаг хуурайшсан гэсэн судалгаа гарсан бөгөөд бэлчээрийг усжуулахад 311 гүний худгийг шинээр гаргахаар, 32 хөв цөөрөм бий болгохоор төлөвлөсөн.
2. Аймгийн бэлчээрийн газрын хувьд доройтолд өртсөн 2.3 сая га, хортон мэрэгчид тархсан 2.4 сая га, элсний нүүлттэй 2.2 сая га, гуу жалга үүссэн, усны эвдрэлд өртсөн 0.4 сая га талбай тус тус эзэлж байгаа тул эдгээр сөрөг нөлөөллийг бууруулахын тулд бэлчээрийн менежментийн чөлөөлөн сэлгэх, хог ургамал хортон мэрэгчидтэй тэмцэх, элсний нүүлтээс хамгаалах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Бэлчээрийн бүх газрыг бэлчээрийн даацад тохируулсан бүс байхаар төлөвлөжээ.
3. Малын тэжээл тарих талбайнуудыг нэмэгдүүлэх, ойн зурвас бүхий тариалангийн талбайг 0.7 сая га-д хүргэх, 171.1 км ойн зурвасыг бий болгохоор тооцон, 10 маршрутаар 74 аялал жуулчлалын бааз, 27 үйлдвэрийн газар бүхий бүс нутгийг төлөвлөсөн.
4. 10 байршилд 14.2 сая га талбайг улсын тусгай хамгаалалтад, 6 байршилд 0.4 сая га талбайг аймгийн тусгай хамгаалалтад, 163 байршилд 1.3 сая га талбайг сумын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн.

Алдархаан, Улиастай сумдаас бусад сумд нь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулалгүйгээр тухайн жилийн газар зохион байгуулалтыг төлөвлөж байгаа нь Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Хот, тосгон бусад суурины газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг зөвхөн тухайн хот, тосгон, бусад суурины харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн боловсрогдож батлагдсан хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу энэ хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ” гэж заасныг зөрчжээ.

Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй сумдын Засаг дарга нар Хот байгуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2.-д “Аймаг, орон нутгийг хөгжүүлэх төсөл, аймгийн төв, нийслэл хот орчмын бүсийн дагуул хот, орон нутгийн зэрэглэлтэй хот болон тосгоны ерөнхий төлөвлөгөө, тэдгээрийн суурь

судалгааг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу төлөвлөлтийн баримт бичгийн зардлыг орон нутгийн төсөвт тусган хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болох шаардлагатай байна.



Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Нексттен инженеринг” ХХК нь Барилга хот байгуулалтын сайдын баталсан зургийн даалгаврын дагуу “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”, “Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар”, “Хот суурин газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар” зэргийг баримтлан иргэд, орон нутгийн удирдлагуудын саналд үндэслэн боловсруулж Барилга хөгжлийн төвийн 2020

оны 1146/2020 магадлалын дүгнэлт гаргуулсан байна.

Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг Аймгийн ИТХ-ын хуралдааны 2019 оны 55 дугаар тогтоолоор дэмжин, 2020 оны 6 дугаар сард Барилга хот байгуулалтын сайдын зөвлөлийн 02 дугаар хуралдаанаар хэлэлцэн, Засгийн газрын 2020 оны 99 дүгээр тогтоолоор баталсан байна. Энэ нь Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хот, тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг аймгийн ИТХ боловсруулж батлах эрхтэй” гэж заасныг зөрчжээ.

Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн үе шатыг 2018-2038 он байхаар тооцон “Ухаалаг ногоон хот байгуулах”, “Баруун бүсийн тулгуур төв болгон хөгжүүлэх” төрийн бодлоготой уялдуулсныг доорх нөхцөлөөс харж болно.

1. Орон сууцны хангамж 2018 онд 18 хувьтай байсныг 2038 он гэхэд 55 хувь болгоно гэж төлөвлөн одоогийн гэр хорооллын суурьшлыг үе шаттайгаар инженерийн шугам сүлжээнд холбохоор тооцсон.
2. Шавар хэрмийг түшиглэсэн аялал жуулчлалын төв цогцолборыг төлөвлөн орчин үеийн тохилог зочид буудал бүхий амралтын газрууд, жуулчны баазуудыг бий болно гэж төсөөлсөн.
3. Төвийн болон Арлын хэсгийн барилгажих талбайг нягтруулж, одоо байгаа гэр хорооллыг нүүлгэн, гадна авто зогсоол, иргэдийн амрах талбай, гадна тохижилт, ногоон байгууламжийг түлхүү шийдсэн.
4. Төлөвлөлтийн гол гол замуудыг аль болох хотыг бүрэн хамруулах, иргэдэд жигд хүртээмжтэй үйлчлэх үүднээс суурьшил бүрд 2-3 чиглэлээр ирж очихоор төлөвлөсөн.
5. Голуудын уулзвар хэсэгт орчин үеийн усан парк, мөсөн гулгуурын талбайг, хотын баруун талд орчин үеийн хүлэмжүүдийг төлөвлөсөн.
6. Өлзийт багийн онгоц буудлын хуучин талбайд шинэ орон сууцны хороолол, баруун бүсийн тулгуур төвийн үйлчилгээний хэсгийн барилга зэргийг барихаар шинээр төлөвлөсөн.

Улиастай хот нь нутаг дэвсгэрийн хэмжээ бага, гэр хороолол ихтэй, инженерийн шугам сүлжээ хуучирсан, цэвэрлэх байгууламжийн хүчин чадал муу, дэд бүтэц сул хөгжсөн зэргээс шалтгаалан дахин төлөвлөлт хийхэд хөрөнгө, нөхөн олговор их шаардсан, аймаг, сумын ИТХ-аар батлагдсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан эсэхийг хянах тогтолцоо бүрдээгүй зэргээс үндэслэн энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн үнэлэх боломжгүй байна гэж үзлээ.

Аудитын илрүүлэлт:

Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд Жинст багийн Баян-Улаан болон Ногоочдын хэсгийн болон Жаргалант багийн баазын нефтийн арын, Нарлаг энгэрийн болон Гандангийн хэсгийн суурьшлын бүс тусгагдаагүй орхигдсон, нийтийн эдэлбэрийн газрууд болон гэр хорооллын айлуудын дундуур төлөвлөгдсөн хатуу хучилттай замууд нь гэр хорооллын айлуудыг нүүлгэн шилжүүлсний дараа хэрэгжих боломжтой. Гэтэл Богдын гол, Жинст багийн суурьшлын бүсийн ихэнхийг 2012 онд иргэдэд өмчлүүлэх шийдвэрийг аймгийн Засаг дарга гаргасан тул нүүлгэн шилжүүлэхэд нөхөн олговор шаардлагатай болсон. “Нексттен инженеринг” ХХК нь хотын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа 498 иргэнээс санал авсан нь иргэдийн оролцоог бүрэн хангаагүй байна. 2024 оноос Засгийн газар аймгуудыг бүсчилсэн байдлаар хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх болсон зэрэг шалтгаануудаас үндэслэн хотын хөгжлийн төлөвлөгөөг тодотгох, шинэчлэх шаардлагатай гэж үзлээ.

Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.4-д “Улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх, тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг боловсруулж, Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих” гэсэн нэмэлт өөрчлөлт 2023 оны 11 дүгээр сард орон 2024 оны 1 дүгээр сарын 01-нэс мөрдөх болсонтой холбоотойгоор Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө аймаг, сумын ИТХ-аар батлагдсан эсэхийг ГЗБГЗЗЕГ хянадаг болсон. Үүний үр дүнд 2024 оны аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнөөс 691 нэгж талбар буюу 2,618.2 га талбайтай газар хасагдсан байна.

Алдархаан сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Эн Эй Пи групп” ХХК нь Барилга хот байгуулалтын сайдын баталсан зургийн даалгаврын дагуу “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”, “Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар”, “Хот суурин газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар” зэргийг боловсруулж Барилга хөгжлийн төвийн 131/2019 магадлалын дүгнэлт гаргуулан аймгийн ИТХ-ын хуралдааны 2019 оны 09 дүгээр тогтоолоор батлуулжээ.

Тус сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа сумдын иргэдээс санал авч, олон нийтийн оролцоог хангаагүй байна.

Алдархаан сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн үе шатыг 2018-2030 он байхаар тооцон, сумын төвийн газар нутгийг ашиглалтаар нь 4 бүсэд хуваан, 6.69 га талбайтай газрыг суурьшлаас чөлөөлөхөөр доорх байдлаар төлөвлөсөн байна.

1. Орон сууц, олон нийтийн бүсийг 63.5 га талбайд төлөвлөн, холимог бүсэд музей, төрийн байгууллагууд, худалдаа үйлчилгээ, зочид буудал баригдахаар, нам давхрын орон сууцны бүсийг инженерийн дэд бүтцэд холбогдсон байдлаар, сайжруулсан гэр сууцны бүсийг дахин төлөвлөх замаар дэд бүтцэд холбохоор, боловсролын бүсэд сургууль, цэцэрлэг шинээр баригдахаар тооцсон.
2. Сумын төвийн зүүн хойд хэсэгт хөнгөн үйлдвэрийн бүсийг 20.1 га талбайд, инженерийн шугам сүлжээ болон зам тээврийн бүсийг 33.3 га талбайд тус тус төлөвлөсөн.
3. Яруугийн голын дагуу ногоон байгууламжийн, соёл амралт, аялал зугаалгын болон хамгаалалтын бүсийг 54.56 га талбайд төлөвлөсөн.

Алдархаан сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнөөс инженерийн шугам сүлжээ болон зам тээврийн бүс нь төлөвлөгдсөний дагуу хийгдсэн бөгөөд сумын төвд хүн амын суурьшил багатай, Улиастай сумтай газар зүйн хувьд ойр байрлалтай зэргээс шалтгаалан инженерийн дэд бүтэц бүхий нам давхрын орон сууцны болон хөнгөн үйлдвэрийн бүс, барилгажилт зэрэг нь хэрэгжиж эхлээгүй байна.

1.2. СУМЫН ЗАСАГ ДАРГА НАР 2023 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖЭЭС ИРҮҮЛСЭН ХҮСЭЛТЭД ҮНДЭСЛЭН БОЛОВСРУУЛЖ, БАТЛУУЛСАН БАЙНА.

Алдархаан, Улиастай сумаас бусад 22 сум нь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй, зөвхөн иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтэд үндэслэн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулан, тухайн шатны ИТХ-аар батлуулан ажиллажээ.

Улиастай сумын ИТХ-ын 2022 оны 40 тогтоолоор тус сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлахдаа 140 нэгж талбарын 21.47 га талбайтай газрыг иргэн, аж ахуй нэгж байгууллагад өмчлүүлж, эзэмшүүлэхээр тусгаснаас гэр бүл, орон сууц хашааны зориулалтаар эзэмшүүлэх 33 нэгж талбарын 2.3 га газар нь Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

Алдархаан сумын ИТХ-ын 2022 оны 16 дугаар тогтоолоор сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлахдаа 206 нэгж талбарын 238.71 га талбайтай газрыг иргэн, аж ахуй нэгж байгууллагад өмчлүүлж, эзэмшүүлэхээр тусгасан нь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Сумдын ИТХ нь Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Тариалангийн газрыг давуу эрхээр эзэмшүүлэх журам”-д эзэмшихээр хүсэлт ирүүлсэн иргэдийн жагсаалтыг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж, санал ирүүлээгүй байхад тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган баталдаг зөрчил нийтлэг байна. Тухайлбал: Сонгино сумын төлөвлөгөөнд 364.7 га талбайтай газрыг, Тосонцэнгэл сумын төлөвлөгөөнд 30.5 га талбайтай газрыг, Түдэвтэй сумын төлөвлөгөөнд 449.9 га талбайтай газрыг, Алдархаан сумын төлөвлөгөөнд 2.2 га талбайтай газрыг тариалангийн газрыг давуу эрхээр эзэмшүүлэхээр тусгасан байна.
- ✓ Сумдын ИТХ-аас газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг батлахдаа газар өмчлүүлэх, эзэмшүүлэх байршил, тоо хэмжээ, зориулалтыг бүрэн тусгаагүй зөрчил нийтлэг илэрч байна.
- ✓ Улиастай сумын Засаг дарга нь Дэчиндаржаалин хийдэд 4.8 га газрыг нэмж эзэмшүүлэхдээ газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд зориулалтыг буруу тусгасан, 0.46 га талбайтай шилжүүлэх боломжгүй цахилгаан дамжуулах кабель бүхий газар, усны эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд орших газар, 2006 онд эзэмших эрх нь баталгаажсан газар зэргийг дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 2.БАТЛАГДСАН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ШААРДЛАГЫН ХЭМЖЭЭНД ХҮРЭЭГҮЙ,ГАЗРЫН ТӨЛБӨРИЙГ БҮРЭН НОГДУУЛАН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

2.1. СУМДЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ШААРДЛАГЫН ХЭМЖЭЭНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.

2023 оны жилийн эцсийн байдлаар аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 77 арга хэмжээний хэрэгжилт нь 24.6 хувийн гүйцэтгэлтэй байгаа бол Улиастай, Алдархаан сумдын хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, аймгийн ГХБХБГ-ын холбогдох албан тушаалтнууд нь архитектор, газрын даамлаас гаргуулж аваагүй байна.

Сумдын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 1,784 нэгж талбарын 348,914.8 га талбайтай газрыг иргэдэд өмчлүүлж, эзэмшүүлэхээр батлуулснаас 1,365 нэгж талбарын 278,757.3 га талбайтай газар буюу төлөвлөсөн нэгж талбарын 75.3 хувь нь хэрэгжжээ. Аудитаар 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг шаардлагын хэмжээнд хүрээгүй байна гэж үзлээ.

Сумдын газрын даамлууд нь газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөг боловсруулахдаа иргэдийн хүсэлтэд дүн шинжилгээ хийдэггүй, төлөвлөж буй газар дээр биеэр очиж үздэггүй, газар эзэмших хүсэлт өгсөн иргэд шаардлагатай баримтуудыг бүрдүүлж хүсэлтээ өгдөггүй зэргээс шалтгаалан газар зохион байгуулалтын төлөвлөгөө бүрэн хэрэгждэггүй байна.

Цаашид газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах,

явцын хяналтыг сайжруулах ажлыг сумдын Засаг дарга, аймгийн ГХБХБГ-аас зохион байгуулах шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ *Отгон, Тосонцэнгэл, Түдэвтэй, Яруу, Цагаанчулуут, Завханмандал сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 1.72 га талбайтай 21 нэгж талбар бүхий газрын өмчлөл хэрэгжээгүй.*
- ✓ *Баянтэс, Нөмрөг, Отгон, Сонгино, Түдэвтэй, Тэлмэн, Яруу, Ургамал, Их-Уул, Цагаанхайрхан, Улиастай, Алдархаан, Асгат, Тэс сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 611.2 га талбайтай 344 нэгж талбар бүхий газрын эзэмшил хэрэгжээгүй.*
- ✓ *Баянтэс, Цагаанхайрхан, Баянхайрхан, Дөрвөлжин, Улиастай, Ургамал, Завханмандал сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 9 нэгж талбар бүхий газрын дуудлага худалдааг явуулаагүй нь Газрын тухай хуулийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 9 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.*
- ✓ *Эрдэнэхайрхан сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 3 нэгж талбарын 35,506.5 га талбайтай газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар тусгасан нь хэрэгжээгүй.*
- ✓ *Ургамал сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эвдрэлд орсон 17.7 га талбайтай газрыг нөхөн сэргээхээр тусгасан нь хэрэгжээгүй.*
- ✓ *Дөрвөлжин сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 8 га талбайтай газарт мод үржүүлнэ гэж тусгасан нь хэрэгжээгүй.*
- ✓ *Асгат сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 797.2 га талбайтай газрын бэлчээрийг өнжөөж хамгаална гэж тусгасан нь хэрэгжээгүй.*
- ✓ *Тэс сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 32,572.5 га талбайтай газарт хортон мэрэгчидтэй тэмцэнэ гэж тусгасан нь хэрэгжээгүй.*
- ✓ *Улиастай сумын Засаг дарга төсөл сонгон шалгаруулалтаар нийтийн эзэмшлийн талбайг цэцэрлэгжүүлэх зориулалтаар 8.17 га талбайг эзэмшүүлэхээр төлөвлөсөн боловч хэрэгжээгүй.*

2.2. АЙМАГ, СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАР ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ШИЙДВЭРИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭН ГАРГААГҮЙ БАЙНА.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 53 дугаар тогтоолоор тайлант онд аймгийн хэмжээгээр 299 иргэнд 34.7 га газрыг өмчлүүлэхээр батлагдсаныг ГЗБГЗЗЕГ -аас хянан 288 иргэнд 33.68 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэх жагсаалтыг Засгийн газрын 2023 оны 105 дугаар тогтоолд тусгуулжээ.

Иргэд газраа өмчлөх хүсэлтээ ирүүлээгүй, сумын Засаг дарга түүний Тамгын газраас газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулаагүйгээс дээрх тогтоолын хэрэгжилт 80.0 хувьтай байна.

Аймаг, сумдын Засаг даргын захирамжаар 222 иргэнд 26.9 га газрыг өмчлүүлэх шийдвэрийг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Газрын тухай хууль,

Засгийн газраас тогтоосон хэмжээ, байршил, зориулалтын дагуу гаргасан байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Улиастай сумын Засаг дарга 2023 оны А/08 дугаар захирамж гарган аймгийн Засаг даргын 2014 оны А/408 дугаар газар өмчлөлийн захирамжийг хүчингүй болгосон;
- ✓ Цагаанхайрхан, Эрдэнэхайрхан сумдын Засаг дарга нар нь Засгийн газрын тогтоолд тусгагдсан ч тухайн сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 3 байршилд газар өмчлүүлсэн;
- ✓ Аймгийн Засаг дарга нь Засгийн газрын тогтоол болон Улиастай сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 1 байршилд газар өмчлүүлэхээр шийдвэр гаргасан нь нь Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.2, 5.1.5.1, 5.1.5.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа нь “Газрын кадастрын мэдээллийн сан”-д шилжсэнтэй холбогдуулан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх зөрчил нь буурсан үзүүлэлттэй байгаа ч сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд 16.8 га талбай бүхий 9 нэгж талбар газрыг эзэмшүүлсэн нь Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 31 дүгээр зүйлийн 31.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг зөрчсөн тул дээрх алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ.

Хүснэгт 1. Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд эзэмшүүлсэн газрын хэмжээ

Сумын нэр	Нэгж талбарын тоо	Газрын хэмжээ /га /
Алдархаан	1	1
Эрдэнэхайрхан	1	0.15
Идэр	1	0.15
Улиастай	6	15.5
Нийт	9	16.8

Аудитын хамрах хугацаанд 17 сумын Засаг дарга нар газар эзэмшүүлэхдээ Газрын тухай хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн 3.5 га талбай бүхий 110 нэгж талбар газрыг үнэ төлбөргүйгээр олгосон нь Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-д “Энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд нэг удаа 5 га хүртэлх газар эзэмшүүлэх асуудлыг аймаг, сум, нийслэлийн Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно” гэж заасныг зөрчжээ. Үнэ төлбөргүй эзэмшүүлсэн газрын үнийг дуудлага худалдааны анхны үнээр тооцоход 20.4 сая төгрөгийн орлогыг аймаг, сумын төсөвт төвлөрүүлээгүй зөрчлийг арилгуулахаар холбогдох албан тушаалтнуудад албан шаардлага хүргүүллээ.

Хүснэгт 2. Хуульд заасан хэмжээг хэтрүүлэн үнэ төлбөргүйгээр эзэмшүүлсэн газрын хэмжээ

Д/д	Сумын нэр	Нэгж талбарын тоо	Хэмжээ /га/	Дуудлага худалдааны анхны үнэ /сая.төг/
1	Алдархаан	17	0.77	4.3
2	Асгат	11	0.37	2.1
3	Баянтэс	20	0.74	4.1
4	Идэр	5	0.18	1
5	Их-Уул	2	0.03	0.2
6	Нөмрөг	2	0.03	0.1
7	Сонгино	1	0.09	0.5
8	Тэлмэн	2	0.17	1
9	Тосонцэнгэл	1	0.03	0.2
10	Улиастай	19	0.7	4.6
11	Ургамал	2	0.08	0.4
12	Цагаанчулуут	3	0.04	0.2
13	Цагаанхайрхан	16	0.11	0.6
14	Цэцэн-Уул	2	0.06	0.3
15	Шилүүстэй	5	0.1	0.6
16	Эрдэнэхайрхан	1	0.01	0.07
17	Яруу	1	0.01	0.09
	Нийт	110	3.52	20.36

Аудитын илрүүлэлт:

- Цагаанчулуут сумын Засаг даргын 2023 оны А/63 дугаар захирамжаар “Биндэрхайрхан ширээ” ХХК-ийн эзэмшиж байсан 115 м² газрын хэмжээг 1200 м² болгон нэмэгдүүлэхдээ дуудлага худалдаа зохион байгуулаагүй, дуудлага худалдааны анхны үнийг төлүүлэн эзэмшүүлсэн нь Газрын тухай хуулийн 33.1.2 дахь заалтыг зөрчсөн.
- Улиастай сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 0.6 га талбайтай сүм хийд шашны байгууллагын зориулалттай газрыг сумын ЗДТГ-т эзэмшүүлэхээр тусган хэрэгжүүлсэн, Улиастай сумын Засаг дарга 2 иргэний, аймгийн Засаг дарга “Ихрийн бууц” ХХК-ийн газар эзэмшлийн зориулалтыг өөрчлөх шийдвэр гаргахдаа хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үндэслээгүй.
- Ургамал сумын Засаг дарга нь ИТХ-ын баталсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зориулалтыг өөрчилж, 1 га талбайтай газрыг иргэнд давуу эрхээр эзэмшүүлсэн.
- Аймгийн Ахмадын хороо нь эзэмшил газраасаа 0.07 га газрыг иргэн Ш.Хадбаатарт үнэ төлбөргүйгээр, сонгон шалгаруулалтгүйгээр хэсэгчлэн шилжүүлэх хүсэлт гаргасныг аймгийн Засаг дарга хяналгүйгээр захирамжилсан нь Газрын тухай хуулийн 38.3 дахь заалтыг зөрчсөн.
- Тосонцэнгэл, Сонгино, Түдэвтэй сумдын Засаг дарга нар Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Тариалангийн газрыг давуу эрхээр эзэмшүүлэх журам”-ыг зөрчиж, шаардлага хангаагүй 90

иргэнд давуу эрхээр 709.2 га талбайтай тариалангийн газрыг эзэмшүүлэх шийдвэрийг гаргасан.

- Их-Уул сумын Засаг дарга нь төмс хүнсний ногооны усалгаатай тариалангийн зориулалттай 1 га талбайтай газрыг эзэмшүүлэх дуудлага худалдааны ялагч нь дуудлага худалдаагаар авсан газрын үнийг төлөөгүй, гэрээ байгуулаагүй байхад тус газрыг сумын Засаг даргын 2023 оны А/226 дугаар захирамжаар давуу эрхээр эзэмшүүлсэн.
- Алдархаан сумын Засаг дарга, газрын даамлууд нар гэр, орон сууцны хашааны болон төмс хүнсний ногооны усалгаатай тариалангийн зориулалттай 1.1 га талбайтай 10 газрыг эзэмшүүлэхээр дуудлага худалдаа зарласан боловч оролцогчгүй байхад иргэдэд эзэмшүүлсэн нь Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.2-д “Төрийн албан хаагч албаны эрх мэдлээ хэтрүүлэх”; 39.1.3-д “Төрийн албан хаагч хуульд нийцээгүй шийдвэр гаргах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.
- Асгат сумын Засаг дарга хилийн цэсийн гадна байгаа 0.1 га талбайтай газрыг 1 иргэнд эзэмшүүлсэн

Иргэн, хуулийн этгээдэд газар шинээр эзэмшүүлэх, эрх шилжүүлэх шийдвэрүүдийн үндэслэлд дараах нийтлэг зөрчил илэрлээ. Үүнд.

- Сумдын Засаг дарга нарын ихэнх захирамжууд нь Захиргааны ерөнхий хуулийн 40.2.3-т “захиргааны актыг гаргах бодит нөхцөл байдал, хууль зүйн үндэслэлийг заах”, “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.2.3-т “... үндэслэл хэсэгт уг баримт бичгийг зохион бүрдүүлэх хууль зүйн үндэслэл, шалтгаан, зориулалт, зорилгыг тодорхой бичнэ” гэснийг баримтлаагүй буюу хууль журмын заалтыг ерөнхий байдлаар үндэслэсэн.
- Шийдвэрийн төслийг “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.1-т заасан төрлүүдээр боловсруулаагүй.
- “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.2 дахь хэсэгт заасан мэдээлэл болох иргэний овог, эцэг /эх/-ийн нэр, регистрийн дугаар, газрын хэмжээ /м.кв-аар/, нэгж талбарын хаяг, дуудлага худалдааны ялагчтай байгуулсан гэрээний огноо, дугаар, хавсралт хуудасны тоо зэргийг шийдвэрт бүрэн тусгаагүй.

Дээрх зөрчлүүд нь “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 5.7.11-т “Зохих журмын дагуу боловсруулж, санал, зөвшөөрөл авсан захирамжлахын баримт бичиг (тогтоол, захирамж, тушаал гэх мэт)-ийн үндэслэл, агуулга нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар хууль, эрх зүйн асуудал хариуцсан бүтцийн нэгж, ажилтан болон байгууллагын удирдлага хянасан байна” гэснийг сумдын Засаг дарга нар хангалтгүй хэрэгжүүлж байгааг харуулж байна.

2.3. ЗАРИМ СУМЫН ЗАСАГ ДАРГА НАР ГАЗРЫН ДУУДЛАГА ХУДАЛДААГ ЗОХИОН БАЙГУУЛАХДАА ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ 10 ДУГААР ТОГТООЛООР БАТЛАГДСАН “ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ, ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ДУУДЛАГА ХУДАЛДАА ЯВУУЛАХ ЖУРАМ”-Г МӨРДӨӨГҮЙ БАЙНА.

Аймгийн хэмжээнд тайлант хугацаанд 165 нэгж талбарын 2,485.9 га талбайтай газарт 201 удаагийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 89 нэгж талбарын 177.9 га талбайтай газрыг 190.6 сая төгрөгөөр худалдан борлуулж, дуудлага худалдааны

ялагчийн дэнчингээр 69.4 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аймгийн ГХБХБГ-ын дуудлага худалдаа хариуцсан мэргэжилтэн тайлант оны эцэст аймгийн төрийн сантай сум бүрээр дуудлага худалдааны орлого, ялагчийн дэнчингийн орлогыг тулган тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.

Хүснэгт 3. Дуудлага худалдаа зохион байгуулсан байдал

д/д	Сумын нэр	төлөвлөсөн дуудлага худалдаа	Худал дагдсан нэгж талбар	Ялагч үнээ төлөөгүй тохиолдол	Оролцогчгүй дуудлага худалдаа	Огт зохион байгуулаагүй дуудлага худалдаа
1	Улиастай	14	4	3	4	3
2	Алдархаан	29	8	1	20	0
3	Асгат	3	2	1		
4	Баянтэс	11	4	0	6	1
5	Баянхайрхан	9		5	2	2
6	Дөрвөлжин	1				1
7	Завханмандал	4	1	1	1	1
8	Идэр	7	5		2	
9	Их-Уул	14	10	3	1	
10	Нөмрөг	0	0	0	0	0
11	Отгон	9	5	1	3	
12	Сантмаргац	2	2	0	0	0
13	Сонгино	8	7	1		
14	Тосонцэнгэл	10	7		3	
15	Түдэвтэй	15	8		6	1
16	Тэлмэн	14	12		2	
17	Тэс	3			3	
18	Ургамал	10	6	1	3	
19	Цагаанхайрхан	4	1	1	1	1
20	Цагаанчулуут	0		0	0	0
21	Цэцэн-Уул	0	0	0	0	0
22	Шилүүстэй	2			2	
23	Эрдэнэхайрхан	1	1			
24	Яруу	4	3		1	
	Нийт	174	86	18	60	10

Аудитын илрүүлэлт:

- ✓ Улиастай, Асгат, Завханмандал, Отгон, Сонгино, Их-Уул, Баянхайрхан, Цагаанхайрхан, Ургамал сумд нь 591.5 га талбайтай газрыг эзэмшүүлэх дуудлага худалдааны 17 ялагч нь дуудлага худалдаагаар худалдан авсан газрын үнэ 413.5 сая төгрөгийг төлөөгүй, гэрээ байгуулаагүй байхад тус сумдын Засаг дарга нар журмын дагуу дуудлага худалдааг дахин зохион байгуулаагүй.
- ✓ Зарим сумдын газрын даамлууд дуудлага худалдааны үр дүнг буруу хаасан

2.4. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЗЭМШИЛД БАЙГАА ГАЗАРТ ТӨЛБӨР, ХУРААМЖИЙГ 171.6 САЯ ТӨГРӨГӨӨР ДУТУУ НОГДУУЛСАН, ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ 218.6 САЯ ТӨГРӨГӨӨР ДУТУУ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.

Аймгийн ГХБХБГ-аас тайлант оны газрын төлбөрийн ногдуулалтыг 1,055.8 сая төгрөгөөр тооцсон бөгөөд гүйцэтгэлээр 729.1 сая төгрөгийн орлого төвлөрсөн мэдээг ирүүлжээ.

Аудитаар газрын төлбөрийн ногдуулалт, гүйцэтгэлийг сум тус бүрээр давхардлыг арилган шалгахад газрын төлбөрийн ногдуулалт, гүйцэтгэл дараах байдалтай байна. Цаашид газрын төлбөрийн систем дэх давхардлыг арилгаснаар газрын төлбөрийн ногдуулалт, гүйцэтгэл үнэн зөв тайлагнагдах боломжтой болно.

Хүснэгт 4. Газрын төлбөр ногдуулалт, төлөлт

Сумын нэр	ГАЗРЫН ТӨЛБӨР НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАН					
	Газрын төлбөрийн ногдуулалт ГХБХБГ (сая төгрөг)		Тайлангийн хугацаанд төлсөн газрын төлбөр (сая төгрөг)	Ногдуулаагүй газрын төлбөр (сая төгрөг)	Дутуу төвлөрүүлсэн газрын төлбөр (сая төгрөг)	татвар төлөгчөөр бүртгүүлээгүй нэгж талбарын тоо
	нэгж талбарын тоо	газрын төлбөр				
Алдархаан	599	43.9	35.4	6.0	8.5	59
Асгат	315	14.2	8.4	0.3	5.8	6
Баянхайрхан	304	22.2	20.6	3.1	1.6	20
Баянтэс	211	5.9	2.7	0.7	3.2	18
Дөрвөлжин	181	580.8	575.3	0.3	5.5	3
Завханмандал	443	15.5	4.9	0.6	10.6	7
Идэр	208	9.4	5.5	7.6	3.8	30
Их уул	370	6.1	0.8	3.7	5.3	7
Нөмрөг	178	5.8	9.7	0.3		7
Отгон	197	3.4	5.2	0.8		17
Сантмаргац	277	19.1	7.7	1.9	11.4	32
Сонгино	136	3.5	1.7	3.6	1.8	9
Түдэвтэй	320	9.0	2.6	3.2	6.4	13
Тэлмэн	325	9.5	6.4	2.1	3.2	15
Тэс	578	12.8	3.2	0.4	9.6	4
Тосонцэнгэл	586	33.2	32.0	24.2	1.2	108
Ургамал	420	113.6	3.5	4.1	110.1	2
Улиастай	1,078	53.3	45.0	98.7	8.4	62
Цагаанхайрхан	314	2.3	2.7	0.4		5
Цагаанчулуут	250	11.9	4.9	0.8	7.0	1
Цэцэн-уул	41	0.5	0.2	0.3	0.3	4
Шилүүстэй	249	4.3	6.2	0.0		2
Эрдэнэхайрхан	377	29.8	18.0	3.9	11.8	8
Яруу	178	9.2	5.9	4.5	3.4	10
Нийт дүн	8,135	1,019.2	808.5	171.6	218.6	449

Сумдын газрын даамлуудын газрын төлбөрийн ногдуулалтыг тулгахад дараах зөрчил илэрлээ.

1. 2110 нэгж талбар бүхий газрын 171.6 сая төгрөгийн ногдуулалтын нэхэмжлэлийг системд үүсгээгүй байснаас 449 нэгж талбар нь Татварын албанд татвар төлөгчөөр бүртгэгдээгүй байна.
2. Газрын төлбөрийн ногдуулалт, гүйцэтгэлийг системд оруулсны дараа давхардлыг шалгадаг тогтолцоо байдаггүй
3. Нөмрөг, Отгон, Цагаанхайрхан, Шилүүстэй сумдаас бусад сумдын татварын улсын байцаагч нар тайлант оны газрын төлбөрийг 218.6 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, газрын төлбөрийн гүйцэтгэлийг газрын даамлуудтай оны эцэст тооцоо нийлж тулгадаггүй зөрчил нийтлэг байна.
4. Дөрвөлжин сумын газрын даамал татан буугдсан "Шинэ дөрвөлжин" ОНӨААТҮГ-ын газрын 1.0 сая төгрөгийн төлбөрийг сумын ЗДТГ-аар төлүүлээгүй
5. Баянтэс, Яруу, Тосонцэнгэл, Асгат, Цэцэн-Уул, Их-Уул сумдын газрын даамлууд нь иргэд аж ахуйн нэгжид эзэмшүүлсэн 536 нэгж талбар бүхий газрын мэдээллийг төлбөрийн мэдээллийн системд бүртгээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Ургамал сумын ИТХ-ын 2022 оны “Сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 35 дугаар тогтоолын 2,3 дугаар хавсралтаар уул уурхайн ашиглалт, олборлолт явуулах зориулалттай газрыг Форсголлд майнинг ХХК-д 25.5 га талбайтай, Түүчээ тэрэг ХХК-д 13.2 га газрын талбайтай ашиглуулахаар баталсан байна. Сумын Засаг дарга “Форсголлд майнинг” ХХК-д уул уурхайн ашиглалт, олборлолт явуулах зориулалттай 25.5 га талбайтай газрыг ашиглуулах шийдвэрийг гаргаагүй байхад 2023-2024 онд тус компани нь уул уурхайн чиглэлийг үйл ажиллагаагаа явуулсаар байна. Ийнхүү газрын ашиглах эрхийг баталгаажуулаагүй нөхцөл байдлаас хамаарч 93.8 сая төгрөгийн газрын төлбөр төлөгдөөгүй байна. Үүнээс гадна “Форсголлд майнинг” ХХК-ийн кемп болон ашиглаж буй хөв цөөрмийн газрууд нь ашиглалтын лицензийн талбайн гадна буюу зөвшөөрөлгүй газар байрлан үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ газрыг дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр Ургамал сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан боловч тус компанийн хайгуулын талбайд багтаж буй гэх шалтгаанаар дуудлага худалдаа амжилтгүй болсон байна. Иймд зөвшөөрөлгүйгээр ашиглаж байгаа тус компанийн кемп болон хөв цөөрмийн газруудын зөрчлийг арилгуулах, уул уурхайн ашиглалт, олборлолт явуулж буй газрын төлбөрийг барагдуулах албан шаардлагыг Ургамал сумын ИТХ, Засаг дарга нарт хүргүүлээ.

2.5. ГАЗАР ОЛГОЛТ, ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН 96.9 ХУВИЙГ ХУУЛИЙН ХУГАЦААНД БҮРЭН ШИЙДВЭРЛЭЖЭЭ.

Аймаг, сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, нутгийн захиргааны байгууллагад аудитын хамрах хугацаанд нийт 1297 өргөдөл, гомдол, хүсэлт ирснээс 390 буюу 30.65% нь газар өмчлөх, эзэмших, эрхийн гэрчилгээ гаргуулах, эрхээ шилжүүлэх зэрэг газрын харилцаатай холбогдолтой байна.

Аймаг, сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, нутгийн захиргааны байгууллагад ирүүлсэн дээрх өргөдөл, гомдол, хүсэлтийн 96.9 хувь нь шийдвэрлэгджээ.

Аймгийн ГХБХБГ-т 2023 онд нийт 255 өргөдөл, гомдол ирснээс 247 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг хүргүүлж, 8 өргөдөл, гомдлыг шийдвэрлээгүй байна.

Аймгийн хэмжээнд тайлант хугацаанд e-gazag.gov.mn цахим хаягаар иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 258 цахим хүсэлтээс 141 хүсэлтийг шийдвэрлэж, 79 хүсэлтийг буцааж, 38 хүсэлтийн өргөдлийг үүсгэн ажилласан бөгөөд 2024 оноос газар зохион байгуулалттай холбоотой өргөдөл, хүсэлтийг 100 хувь цахим хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд газар зохион байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой нийт 21 маргаан шүүхийн шатанд бүртгэгдсэнийг 100 хувь шийдвэрлэн ажилласан байна.

Хүснэгт 5. 2023 онд шүүхээр шийдвэрлэгдсэн газартай холбоотой маргааны судалгаа

№	Маргааны төрөл	2023	
		Ирсэн маргааны тоо	Шийдвэрлэсэн маргааны тоо
1	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө	1	1
2	Газар өмчлөх	5	5
3	Газар эзэмших	12	12
4	Газар ашиглах	-	-
5	Бусад	3	3
Нийт		21	21

Эх сурвалж: Завхан аймаг дахь Шүүхийн Тамгын газраас ирүүлсэн судалгаа

Тус аймгийн Тэс сум нь БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1959 оны 5-р сарын 31 ний зарлигаар Тэс сум нэртэйгээр хөдөөгийн 3 багтай, 229,828 га газар нутагтайгаар үүсгэн байгуулагдаж байжээ. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1974 оны 216 дугаар зарлигаар Тэс сумын Дэлгэрэх нэгдлийг Баянтэс сумын Жаргалант амьдрал нэгдэлтэй нэгтгэснээр Баян тэс суманд Дэлгэрэх амьдрал нэртэйгээр байгуулж Тэс сумын Нисэг, Баян-Уул багийн хүн ам, газар нутгийг Баянтэс суманд шилжүүлсэн. Үүний дараагаар 1991 онд Баянтэс сумаас дахин Баян-Уул, Нисэг багуудыг хүн ам, малын хамтаар Тэс суманд нэгтгэсэн боловч газар нутгийн асуудал албан ёсоор шийдвэрлэгдээгүй өдийг хүрсэн байна.

Хилийн цэсийн энэхүү зөрүүтэй нөхцөл байдлаас үүдэлтэйгээр Тэс сумын ИТХ, Засаг даргаас нутаг дэвсгэртээ газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж хангахад хүндэрлтэй нөхцөл байдал үүссэн, мөн тус сумын Нисэг багийн 198 өрхийн 110 өвөлжөө, хаваржаа, Хилийн цэргийн 0277-р ангийн 1, 2 дугаар застав, Гаалийн хороо, хүүхдийн цэцэрлэг, Тэс-Агро махны үйлдвэр, Хаан банк, багийн төв, иргэдийн эзэмшлийн 60 орчим хашааны газар болон Баян-Уул багийн 142 өрхийн 105 өвөлжөө, хаваржаа, багийн төв, худаг зэрэг газруудыг эзэмшүүлэх шийдвэр гаргах боломжгүй байгаа зэргээс шалтгаалан иргэд, аж ахуйн нэгжүүд хохирч байгаа нөхцөл байдал үүссэн байна.

Иймд Тэс сумын газар нутгийг АИХ-ын Тэргүүлэгчдийн 1959 оны зарлигийг үндэслэн анх тогтоогдсоноор баталгаажуулах асуудлыг холбогдох хууль, журамд нийцүүлэн шийдвэрлүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлээ.

БҮЛЭГ 3. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

3.1. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ БОЛОН ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН ГАРГАСАН ШИЙДВЭРТ АЙМАГ, СУМДЫН ИТХ-ААС ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ХЯНАЛТ ТАВИН АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас 2023 онд газар зохион байгуулалттай холбоотой дараах 4 тогтоол гарсан байна. Үүнд:

- 2024 онд аймгийн хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил зориулалтын саналыг Засгийн газарт уламжлах тухай /2023.12.02 Дугаар 96/
- Хот суурин газрын суурьшлын бүсийн тэг гортгийг тэлэх, шинэчлэн тогтоох, газрын нэгдмэл сангийн ангилал шилжүүлэх саналыг Засгийн газарт уламжлах тухай /2023.12.02 Дугаар 97/
- Газрын дуудлага худалдааны орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, зарцуулах, тайлагнах журмыг шинэчлэн батлах тухай /2023.12.02 Дугаар 98/
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөлт оруулах тодотгох санал боловсруулах комисс томилох тухай /2023.12.02 Дугаар 99/

Аймгийн ИТХ-аас 2023 онд дээрх 4 тогтоолоос өөр газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавиагүй, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнээгүй зэрэг нь Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-т “Аймаг, сумын ИТХ нь газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэх”, 57 дугаар зүйлийн 57.1-д “Газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Засгийн газар, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу хяналт тавина” гэж заасныг зөрчсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 99 дүгээр тогтоолоор Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөлт оруулах тодотгох санал боловсруулах комисс томилогдсон боловч тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй байна.

Сумдын ИТХ нь Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэд хяналт тавих зохицуулалттай ч тус хяналтаа хангалтгүй хэмжээнд хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- Сумын Засаг даргын өргөн мэдүүлсэн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлахдаа Газрын тухай хууль тогтоомжийг зөрчин хуульд заасан хэмжээнээс илүү олгохоор, тариалангийн газрыг журам зөрчин давуу

эрхээр олгох болон дуудлага худалдаа явуулах газрыг оновчтой төлөвлөөгүйгээр газрыг эзэмшүүлэхээр тусгасан;

- Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих арга хэмжээ зохион байгуулдаггүй;
- Жилийн эцсийн хуралдаанаар тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг сонсох төдий үйл ажиллагаа явуулдаг, Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэдэггүй,
- Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдаагүй шалтгаан нөхцөлийг тодорхойлдоггүй зэрэг нийтлэг зөрчил илэрлээ.

Иймд аймаг, сумдын ИТХ-аас тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлахдаа Газрын тухай хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, газар эзэмших, ашиглахтай холбогдуулан гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд тавих хяналтыг сайжруулах, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэж ажиллах талаар аймаг, сумдын ИТХ-д зөвлөмж хүргүүлээ.

3.2 АЙМГИЙН ГХБХБГ-ААС ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАСАН Ч ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Аймгийн ГХБХБГ-ын улсын байцаагч нь тайлант онд Засгийн газрын “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 2023 оны 79 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 74 дүгээр тушаал, Барилга хот байгуулалтын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оны 02-00/12 дугаар удирдамжийн дагуу Тэлмэн, Отгон, Баянтэс сумдын газар олголтын үйл ажиллагаа, Газрын тухай хууль, журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийжээ. Уг хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар улсын байцаагч нь Тэлмэн, Отгон, Баянтэс сумдын Засаг дарга нарт албан шаардлага хүргүүлснээс зөвхөн Тэлмэн сумын Засаг дарга биелэлтийг ирүүлсэн байна.

Албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байгаа шалгаан нь Отгон, Баянтэс сумдын Засаг дарга, газрын даамлууд нь хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж ажиллаагүй, улсын байцаагч гаргасан албан шаардлагынхаа биелэлтэд гүйцэтгэлийн хяналт тавиагүйгээс шалтгаалсан байна. Хариуцсан ажлаа хангалтгүй биелүүлсэн улсын байцаагчид зөрчлийг арилгуулах хугацаатай үүргийг албан шаардлагаар хүргүүлээ.

Аймгийн ГХБХБГ-ын даргын 2023 оны 05 сарын 15 өдөр баталсан “Газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх” удирдамжийн дагуу Идэр, Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул сумдад газар олголтын захирамж, байршил, хэмжээ, зориулалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, мөрдөлт зэрэгт хяналт тавьж ажилласан байна. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчил, болон сумдын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байгаа зэргээс хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний үр дүнг хангалтгүй байна гэж дүгнэлээ.

Аймгийн ГХБХБГ-аас сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэрэгжилт, дуудлага худалдааны үр дүн, газрын төлбөрийн ногдуулалт, газар олголт зэрэгт тавих хяналт хангалтгүй байна.

3.3 ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМД ГАЗАР ЭЗЭМШИГЧ, ӨМЧЛӨГЧИЙН БҮРТГЭЛД ХЯНАЛТ ТАВЬЖ, ЗӨРЧЛИЙГ АРИЛГАН АЖИЛЛАЖ БАЙНА.

Аймгийн хэмжээнд тайлант оны эцэст газрын мэдээллийн нэгдсэн системд 26,279 нэгж талбар бүхий газар бүртгэлтэй байна.

Тайлант хугацааны идэвхгүй төлөвт байгаа нэгж талбарын тоо нь 2017 оны мөн үеэс 6167 нэгж талбараар буурч 985 нэгж талбар болсон сайн тал байна.

Газрын мэдээллийн нэгдсэн системд системд 4,639 нэгж талбар бүхий газрын бүртгэл зөрчилтэй байна. Энэ нь бичиг баримт дутуу, эзэмшил газрыг зөвшөөрөлгүй сунгасан, захирамж, гэрчилгээний хэмжээ зөрсөн, мэдээллийн санд зориулалт буруу бүртгэгдсэн, мэдээллийн санд бүртгэлгүй, зөвшөөрөлгүй газар суурьшсан гэх зэрэг шалтгаануудаас үүссэн байна.

Газрын бүртгэлийн зөрчлүүд арилахгүй байгаа шалтгаан нь газар эзэмшиж буй иргэд нь өөр аймаг, сум, хот руу шилжсэн, нас барсан, бичиг баримтын зөрчлийг арилгах хүсэлтээ өгдөггүй, зөвшөөрөлгүйгээр захирамжийн дээрх газрын хэмжээнээс илүү эзэмшил газрыг сунган ашигладаг зэргээс шалтгаалж байна.

Хүснэгт 6. Газрын мэдээллийн нэгдсэн систем дэх газар эзэмшигч, өмчлөгчийн бүртгэл

Д/д	Сумын нэр	Нийт нэгж талбарын тоо	2017 он Идэвхгүй газар	2023 он Идэвхгүй газар	Зөрчилтэй газрын тоо
1	Алдархаан	1732	86	44	725
2	Асгат	355	33		44
3	Баянхайрхан	518	2		78
4	Баянтэс	672	104	50	377
5	Дөрвөлжин	528	138	1	86
6	Завханмандал	529	55	15	173
7	Идэр	636	243	10	96
8	Их-Уул	1228	967	17	338
9	Нөмрөг	900	49	1	112
10	Отгон	810	140	14	195
11	Сантмаргаз	600	1	4	153
12	Сонгино	612	13	8	169
13	Түдэвтэй	787	175	22	50
14	Тэлмэн	1016	270	5	15
15	Тэс	843	149	12	72
16	Тосонцэнгэл	5104	2160	67	143
17	Ургамал	707	17		81
18	Улиастай	6025	2138	622	1093
19	Цагаанхайрхан	513	160	25	148
20	Цагаанчулуут	463	5	2	15
21	Цэцэн-Уул	381	13	18	105
22	Шилүүстэй	418	109	14	117

23	Эрдэнэхайрхан	454	58	4	98
24	Яруу	448	67	30	156
	Нийт	26,279	7,152	985	4,639

Газрын төлбөрийн нэгдсэн системийг аймгийн Татварын хэлтсийн төлбөрийн ногдуулалттай тулгахад 46.4 сая төгрөгөөр, 17 сумын кадастрын системд байгаа газар эзэмшигчийн бүртгэл нь газрын төлбөрийн системийн бүртгэлээс 2060 нэгж талбараар зөрсөн зэрэг нь газрын даамлуудын болон цахим бүртгэлийн давхардлаас шалтгаалсан байна.

Газрын биржийн цахим систем нь газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хот байгуулалтын болон газрын кадастрын мэдээллийн системүүдтэй бүрэн уялдаагүй, газрын дуудлага худалдаа амжилтгүй болсон тохиолдолд нэгж талбар идэвхгүй төлөвт шууд шилждэггүй зэргээс шалтгаалан зарим сумдын газрын даамал тухайн нэгж талбарыг хүсэлт гаргасан иргэдэд олгож байгаа зөрчил илэрлээ.

Цаашид газрын кадастрын болон газрын төлбөрийн системийг шинэчлэх, газрын бүртгэлийн давхардлыг арилгах, газрын биржийн цахим системийг газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хот байгуулалтын болон газрын кадастрын системүүдтэй уялдуулах хүсэлтийг ГЗБГЗЗЕГ-д тавин шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Улиастай сумын газрын даамал аймаг, сумын Засаг даргын захирамж гарсан байхад 6 иргэний газар өмчлөх, эзэмших эрх, бусдад шилжүүлсэн шийдвэрийн дагуу газар олгоогүй.
- ✓ Алдархаан сумын газрын даамал сумын Засаг даргын захирамж гарсан байхад 2 иргэний 0.26 га талбайтай газар өмчлөх, эзэмших эрхийг олгоогүй.
- ✓ Улиастай, Алдархаан сумын хилийн цэс тогтоохтой холбоотойгоор Улиастай сумын нэгж талбарын дугаар бүхий 49 газар Алдархаан сумын кадастрын системд бүртгэгдсэн.
- ✓ Татан буугдсан "Шинэ дөрвөлжин" ОНӨААТҮГ-ын эзэмшилд байсан 25 газар эзэмших эрхийг Дөрвөлжин сумын ЗДТГ-т шилжүүлэн бүртгээгүй.
- ✓ Асгат сумын газрын даамал 3 иргэний 0.31 га талбайтай газар эзэмших эрхийг бусдад шилжүүлсэн шийдвэрийг мэдээллийн системд бүртгээгүй.
- ✓ Их-Уул, Тосонцэнгэл, Отгон, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Шилүүстэй сумдад байрлах мэдээлэл холбоо сүлжээний кабелийн шугамын 1,486.2 км хамгаалалтын зурвас, Мобикомын шилэн кабелийн 310 км хамгаалалтын зурвасыг кадастрын мэдээллийн системд бүртгээгүй.
- ✓ Тосонцэнгэл, Отгон, Алдархаан сумдын цэвэр, бохир усны шугамын хамгаалалтын зурвасыг мэдээллийн системд бүртгээгүй.
- ✓ Улиастай, Алдархаан, Улиастай сумдаас бусад 22 сумын дулааны шугамын хамгаалалтын зурвасыг мэдээллийн системд бүртгээгүй.

Аймгийн хэмжээнд мэдээлэл холбоо сүлжээний кабелийн шугамын хамгаалалтын зурвас, трассын зураг, дулааны шугамын хамгаалалтын зурвасыг холбогдох хангагч, ашиглалт хариуцсан байгууллагатай хамтран мэдээллийг кадастрын мэдээллийн санд бүртгэж баталгаажуулах зөвлөмжийг аймгийн ГХБХБГ-т хүргүүллээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Алдархаан, Улиастай сумдаас бусад 22 сум нь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй, зөвхөн иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтэд үндэслэн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулан, тухайн шатны ИТХ-аар батлуулсан байна.
2. Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд Жинст багийн Баян-Улаан болон Ногоочдын хэсгийн, Жаргалант багийн баазын нефтийн арын, Нарлаг энгэрийн болон Гандангийн хэсгийн суурьшлын бүс тусгагдаагүй орхигдсон, газар нутгийн хэмжээ бага тэлэх боломжгүй тул хотын хөгжлийн төлөвлөгөөг тодотгох, шинэчлэх шаардлагатай байна.
3. Улиастай сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнөөс гэр бүл, орон сууц хашааны зориулалтаар эзэмшүүлэх 33 нэгж талбарын 2.3 га газар нь Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдаагүй байна.
4. Иргэд газраа өмчлөх, эзэмших хүсэлтээ ирүүлээгүй, сумдын Засаг дарга түүний Тамгын газраас газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажил зохион байгуулаагүйгээс газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 75.3 хувь байгааг шаардлагын хэмжээнд хүрээгүй байна гэж үзлээ.
5. Улиастай сумын Засаг дарга нь 4.8 га газрын эзэмших зориулалтыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд буруу тусгасан, 0.46 га талбайтай шилжүүлэх боломжгүй цахилгаан дамжуулах кабель бүхий газар, усны эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд орших газар, 2006 онд эзэмших эрх нь баталгаажсан газар зэргийг дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр төлөвлөсөн байна.
6. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй нэгж талбар, байршилд болон хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн, зарим иргэдэд давуу эрхээр газар олгожээ.
7. Газрын дуудлага худалдааг зохион байгуулахдаа “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-г мөрдөөгүй байна.
8. Аймгийн ГХБХБГ нь иргэн, хуулийн этгээдийн эзэмшилд байгаа газарт төлбөр, хураамжийг 171.6 сая төгрөгөөр дутуу ногдуулсан, газрын төлбөрийн орлогыг 218.6 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.
9. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт болон, газар эзэмших, ашиглахтай холбогдуулан гаргасан шийдвэрт аймаг, сумдын ИТХ-аас болон

аймгийн ГХБХБГ-аас тавих хяналт хангалтгүй байна.

10. Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн систем, Газрын биржийн цахим систем, газар зохион байгуулалт хот төлөвлөлийн мэдээллийн систем хоорондын уялдаа хангалтгүй, газар эзэмшигчийн бүртгэл давхардсан байна.
11. Аймгийн хэмжээнд мэдээлэл холбоо сүлжээний кабелийн шугамын хамгаалалтын зурвас, трассын зураг, дулааны шугамын хамгаалалтын зурвасыг кадастрын мэдээллийн санд бүртгээгүй байна.
12. Тэс, Баянтэс сумдын хилийн цэсийн зөрүүтэй нөхцөл байдлаас үүдэлтэйгээр Тэс сумын ИТХ, Засаг даргаас нутаг дэвсгэртээ газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж хангуулахад хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн байна.
13. Аймгийн ГХБХБГ-т 2023 онд нийт 255 өргөдөл, гомдол ирснээс 247 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг хүргүүлж, 8 өргөдөл, гомдлыг шийдвэрлээгүй байна.
14. Улиастай, Алдархаан сумын нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөлт оруулах тодотгох санал боловсруулах комисс томилогдсон боловч тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй байна.
15. Ургамал сумын ГЗБТ-нд туссан уул уурхайн ашиглалт, олборлолт явуулах 25.5 га талбайг ашиглуулах шийдвэр гараагүй боловч Форс голлд майнинг ХХК нь аудитын хамрах хугацаа болон 2024 онд үйл ажиллагаагаа явуулсан, тус компанийн кемп болон ашиглаж буй хөв цөөрмийн газрууд нь ашиглалтын лицензийн талбайн гадна буюу зөвшөөрөлгүй газар байрлан үйл ажиллагаа явуулж байна.

ЗӨВЛӨМЖ:**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА Б.САНЖСҮРЭН-д**

1. Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд тавих хяналтыг сайжруулах, газар зохион байгуулалттай холбоотой аймгийн Засаг даргын тайланг хэлэлцэн дүгнэх;
2. Улиастай, Алдархаан сумын нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөлт оруулах тодотгох санал боловсруулах комисс томилох тухай аймгийн ИТХ-ын 2023 оны 99 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах;

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА НАРТ:

1. Сумын Засаг даргын өргөн мэдүүлсэн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлахдаа Газрын тухай хууль тогтоомжийг мөрдөх;
2. Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу тавих хяналтыг сайжруулах, тухайн шатны Засаг даргын тайланг хэлэлцэн дүгнэж байх;

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.ӨНӨРБАЯР-т:

1. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй сумдыг төлөвлөгөөтэй болгох ажлыг сумдын Засаг дарга нартай хамтран хэрэгжүүлэх;
2. Газрын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;
3. Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдох үйл ажиллагаанд үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлэх;
4. Аймгийн хэмжээнд газар ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн Газрын тухай хууль тогтоомжийн мөрдөлтөд газар, байгаль орчин, ургамал, хорио цээр, эрүүл ахуй, геологи, уул уурхай зэрэг мэргэжлийн байгууллагуудыг оролцоотой хяналт шалгалтыг зохион байгуулах;
5. Тэс сумын газар нутгийг АИХ-ын Тэргүүлэгчдийн 1959 оны зарлигийг үндэслэн анх тогтоогдсоноор баталгаажуулах асуудлыг холбогдох хууль, журамд нийцүүлэн шийдвэрлүүлэх.

УЛИАСТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА Ч.НАРАНБАТ-д:

1. Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол оруулах;
2. Улиастай сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах, төлөвлөлтийн чанарыг сайжруулах, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах.

СУМЫН ЗАСАГ ДАРГА НАР-Т:

1. Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх
2. Газрын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах
3. Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгох шийдвэр гаргахдаа Захиргааны ерөнхий хууль, Газрын тухай хууль тогтоомж болон Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмыг мөрдөн ажиллах.

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР-Т:

4. Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэрэгжилт, дуудлага худалдааны үр дүн, газрын төлбөрийн ногдуулалт, газар олголт зэрэгт тавих хяналтыг үр дүнтэй төлөвлөн хэрэгжүүлэх;
5. Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид болон иргэдэд Газрын тухай хууль тогтоомжийг сурталчлах ажил, арга хэмжээ зохион байгуулах;
6. Газрын төлбөрийн ногдуулалт, гүйцэтгэлийг системд оруулсны дараа давхардлыг аймаг, сумын түвшинд шалган арилгах, газрын төлбөрийн ногдуулалт, гүйцэтгэлийг аймгийн Татварын газрын мэдээлэлтэй тулган баталгаажуулах;
7. Газрын кадастрын болон төлбөрийн системийг шинэчлэх, давхардлыг арилгах, газрын биржийн цахим системийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөний болон газрын кадастрын системүүдтэй уялдуулах хүсэлтийг ГЗБГЗЗЕГ-д тавин шийдвэрлүүлэх;
8. Аймгийн хэмжээнд мэдээлэл холбоо сүлжээний кабелийн шугамын хамгаалалтын зурвас, трассын зураг, дулааны шугамын хамгаалалтын зурвасыг холбогдох хангагч, ашиглалт хариуцсан байгууллагатай хамтран мэдээллийг кадастрын мэдээллийн санд бүртгэж баталгаажуулах;
9. 2023 онд ирсэн шийдвэрлээгүй 8 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж хариуг хүргүүлэх;

АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗАР-Т

1. Газрын төлбөрийн ногдуулалт, гүйцэтгэлийг аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэдээлэлтэй тулгаж зөрүүг арилгах;
2. 2023 онд дутуу төвлөрүүлсэн 218.6 сая төгрөгийн газрын төлбөрийн орлогын биелэлтийг хангуулах

Аудитаар өгсөн зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу төлөвлөгөө гарган ирүүлж, хэрэгжилтийг ханган, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ЗАВХАН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-26-20
И-мэйл: zavkhan@gazar.gov.mn

2024.12.06 № 474
танай 2024.12.02 -ны 632 т

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирсэн “Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитын тайлангийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна.

1.Засгийн газраас тогтоосон тариалангийн бүс нутагт давуу эрхээр эзэмшүүлэх заалт 2003 оны 28 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтад байхгүй байгаа тул давуу эрхийн журмыг бүх аймаг суманд хэрэгжих боломжтой заалт гэж үзэж байна.

2.2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг яагаад шаардлага хангаагүй гэж үзэж байгаа талаар тайлбар авах саналтай байна.

3.Тухайн жилд төлөвлөж байгаа нэгж талбаруудаас иргэд өргөдлөө өгч газраа авч байгаа бөгөөд иргэдийн өргөдөл хүсэлт ирээгүй байршил дээр газар олгох боломжгүй. Мөн газрыг дуудлага худалдаа зарлаж иргэдэд олон нийтэд нээлттэй байршуулж явагддаж байгаа учраас дуудлага худалдаа оролцогчгүй, оролцоод ялсан нь иргэн, аж ахуй нь мөнгөө төлдөггүй зэргээс шалтгаалж газар олголт хийх боломжгүй учраас төлөвлөгөөний биелэлт шаардлага хангаагүй гэсэн дүгнэлтэнд санал нийлэхгүй байна.

4.Отгон, Тосонцэнгэл, Түдэвтэй, Яруу, Цагаанчулуут, Завханмандал сумын 38 нэгж талбар гэж буруу бичсэн байгаа нягтлуулах саналтай байна.

5.Баянтэс, Түдэвтэй, Цагаанхайрхан, Баянхайрхан, Ургамал, Дөрвөлжин Улиастай, Алдархаан Завханмадал сумдын 16.48 га буюу 14 нэгж талбар дээр дуудлага худалдаа зарласан бөгөөд тухайн дуудлага худалдаанууд оролцогчгүй, оролцогч нар үнийн санал хэлээгүйгээс болж дуудлага худалдаа цуцлагдсан байгаа. “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журмын” 10.1.1, 10.1.2, 10.1.4 дэх заалтыг зөрчиж байна гэсэн дүгнэлттэй санал нийлэхгүй байгаа тул дахиж нягтлуулах саналтай байна. Дээрх журмын /10.2.Дуудлага худалдааг дахин явуулах шийдвэрийг тухайн шатны Засаг дарга

буюу чөлөөт бүсийн захирагч гаргах бөгөөд дуудлага худалдааны зарыг дахин дуудлага худалдаа явуулах өдрөөс хуанлийн 14-өөс доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ./ гэсэн заалт байгаа тул хууль, журам зөрчөөгүй гэж үзэж байна.

6.Отгон, Цагаанхайрхан, Эрдэнэхайрхан сумдад нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 53 дугаар тогтоолоор Засгийн газарт уламжласан тогтоол, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 105 дугаар тогтоолоор батлагдсан тогтоолуудын дагуу 4 байршилд газар өмчлүүлэх захирамж гарсан бөгөөд дээрх 3 суман дээр хууль зөрчсөн асуудал байхгүй тул дахиж нягтлуулах саналтай байна.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНЧУЛУУН



**ЗАВХАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ**

81090 Улиастай, Завхан аймаг

Утас/Факс: 7046-2211

И-мэйл: zavkhan@itkh.za.gov.mn

2024.12.04 № 4188
танай 2024.12.02-ны № 630 Т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Д.БАТ-УНДРАА ТАНАА**

“Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитын тайлангийн төсөлд саналгүй болно.

НАРИЙН БУЛГИЙН
ДАРГА  С.БОЛДБААТАР



АҮРГЭЙН 0039295 0922020326

8109006310




**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: za@zavkhan.gov.mn

2024. 12. 11 № 6/1269
танай _____-ны № _____ Т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” аудитын тайлангийн төсөлд өгөх саналгүй.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Д.АЗЖАРГАЛ



САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

№	ГХБХБГ-аас ирүүлсэн санал	Саналыг шийдвэрлэсэн байдал
1	Засгийн газраас тогтоосон тариалангийн бүс нутагт давуу эрхээр эзэмшүүлэх заалт 2003 оны 28 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтад байхгүй байгаа тул давуу эрхийн журмыг бүх аймаг суманд хэрэгжих боломжтой заалт гэж үзэж байна.	Саналын дагуу тайлангийн төслөөс Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоол гэснийг хассан.
2-3	2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг яагаад шаардлага хангаагүй гэж үзэж байгаа талаар тайлбар авах	2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг дахин хянаж, дуудлага худалдааны оролцогчгүй тохиолдлыг биелснээр тооцсон, “Төлөвлөгөөний хэрэгжилт шаардлагын хэмжээнд хүрээгүй байна” гэж дүгнэсэн.
4	Отгон, Тосонцэнгэл, Түдэвтэй, Яруу Цагаанчулуут, Завханмандал сумын 38 нэгж талбар гэж буруу бичсэн	Тосонцэнгэл сумын 17 нэгж талбар зөрүүтэй байсныг залруулсан.
5	Баянтэс, Түдэвтэй, Цагаанхайрхан, Баянхайрхан, Ургамал, Дөрвөлжин, Улиастай, Алдархаан Завханмандал сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 16.48 га талбайтай 14 нэгж талбар бүхий газрын дуудлага худалдааг явуулаагүй гэснийг дахин нягтлах	Дахин хянаж дуудлага худалдаа зохион байгуулаагүй сумдын мэдээллийг тайланд хүснэгтээр тусгасан
6	Засгийн газрын тогтоолд тусгагдсан байршилд газар өмчлүүлээгүй гэснийг дахин нягтлах	Газрын тухай хуульд заасны дагуу саналыг хүлээж авах боломжгүй